



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2005 оны 9 сарын 22 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, "Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 29 дүгээр тушаалыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилтан, албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн, батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв /Ц.Нарандэлгэр/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2004 оны 158 дугаар захирамжийн 3 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2005оны 9 сарын 22 ны өдрийн 380 урлаар... захирамжийн хавсралт

### ХҮҮХДИЙН СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ТӨВИЙН ДҮРЭМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв нь /цаашид Төв гэх/ нь нийслэлийн хэмжээнд эцэг эхийн хараа хяналтаас гарч хүнд нөхцөлд амьдарч байгаа, асран хамгаалагч нь нас барсны улмаас албан ёсны асран хамгаалагч хүмүүжүүлэгчийн үүргийг хүлээх төрө, төрөгсөд, хамаатан садангүй болон зайлшгүй асрамж, хамгааллын үйлчилгээ авах шаардлагатай 4-18 насны хүүхдүүдэд байнга болон түр хугацаанд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

1.2.Төвийн үйл ажиллагааны зорилго нь байнгын болон түр хугацаагаар байрлаж буй хүүхдийг амьдрах нөхцөл, хоол, хувцас, хэрэгцээт зүйлээр хангах, хүүхдийн эрхэд тулгуурласан, эрүүл мэнд, соёл, ахуй, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, элдэв муу зуршлаас хөндийрүүлэх, боловсрол нөхөн олгох, эцэг эхийнх нь оронд халамжлан өсгөн хүмүүжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах арга ухаанд сургах, гэр бүл төвтэй хөгжлийн чиг баримжааг баримтлан хууль ёсны эрх ашгийг нь хамгаалахад оршино.

1.3. Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрийг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Төв нь ашгийн бус, төрийн байгууллага юм.

1.5. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээг Хөдөлмөр халамжийн асуудал эрхэлсэн байгууллагаас авч Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үйл ажиллагаагаа явуулна..

1.6. Төв нь Нийслэлийн Засаг дарга болон Засаг даргын орлогчийн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж, тайлагнана.

1.7. Төвийн үйл ажиллагаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч бөгөөд түүний Тамгын газар хяналт тавина.

1.8. Төв нь энэхүү дүрмийг үндэслэн өөрийн дотоод журмаа боловсруулан, хамт олны хурлаар хэлэлцүүлж захирлын тушаалаар батлана.

1.9.Төв нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэв-юмэл хуудас хэрэглэж банкинд харилцах данстай байна.

## **Хоёр. Төвийн удирдлага зохион байгуулалт:**

2.1. Төвийн бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, захирлыг томилж чөлөөлнө.

2.2. Төвийн захирал эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

2.3. Төвийн захирал нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан төвийн албан хаагч, багш, ажилтнуудыг томилж чөлөөлнө.

2.4. Төвийн захирлын дэргэд байгууллагын зорилт, цаг үеийн шуурхай шийдвэр, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг ХСХТТ-ийн захирал батална.

2.5. Зовлол нь төвийн хөрөнгө зарцуулалт, төлөвлөгөөний хэрэгжилт, хүүхдийн эрх зөрчигдөж буй эсэхэд дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах эрхтэй.

2.6. Төвийн захирал нь төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлэн төсвийг зориулалтын дагуу зарцуулна.

2.7. Төвийн захирал нь ажилтнуудтайгаа бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батална.

2.8. Төв нь эрхэлсэн хүрээний асуудлаа бие дааж шийдвэрлэхийн зэрэгцээ шаардлагатай асуудлаар бусад газартай хамтран ажиллана.

2.9 Төвд 4-18 хүртэлх насны хагас ба бүтэн өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан, орон гэрээсээ дайжсан хүүхдүүдийг Хүүхдийн хаяг тогтоох тасгийн даргын тодорхойлолт болон нийслэл, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн авна.

2.10. 18 нас хүрсэн хүүхдийг "Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай төв"-д болон Олон улсын ТББ-д шилжүүлнэ.

2.11. Төв нь хүүхдийн эцэг эх тэднийг төлөөлөх хүмүүс, холбогдох байгууллага бусад газартай байнгын холбоотой ажиллах ба тэдэнтэй биечлэн уулзах /захидлаар харилцах, уулзалт ярилцлага/ зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн ажлаар хүүхдийг гэр бүлд нь ойртуулах чиглэлийг баримтлан үйл ажиллагаагаа явуулна.

2.12. Төв нь орон тооны мэргэжлийн нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, эмч, сувиллагчтай байна. Бусад ажилтан, албан хаагчдыг төв оорвоо зохион байгуулан ажиллуулж болно.

## **Гурав. Төвийн үүрэг**

3.1. Төв нь Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хугацааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3.2. Холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон түүний тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг хугацаанд нь тайлагнана.

3.3. Төвөөр үйлчлүүлж буй хүүхдийг өдөр тутам асран хүмүүжүүлж, амь нас, эрүүл мэндийн байдлыг албан ёсоор хариуцна.

3.4. Төвд ирсэн хүүхэд бүрт нөхцөл байдлын үнэлгээ хийж, хэрэгцээ сонирхолд нь тулгуурлан Хүүхдийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана.

3.5. Хүүхэд бүрийг бичиг баримтжуулах, эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулна.

3.6. Төвөөр үйлчлүүлж буй хүүхдийг тохитой амьдрах зориулалт бүхий орон байр, тавилга, хоол хүнс, хувцас, эм, тоглоом наадгай, хичээлийн болон ариун цэврийн хэрэгслээр хангана.

3.7. Хүүхдийн зан үйлийг өөрчлөх, эрүүл мэнд, сэтгэл санааг сэргээн нийгэмшүүлэх сургалт зохион байгуулах үйлчилгээ явуулна.

3.8. Боловсрол нөхөн эзэмшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох болон албан бус сургалтыг явуулна.

3.9. Хүүхдэд шаардлагатай чиглэлээр ганцаарчилсан болон бүлгээр зөвлөгөө өгнө.

3.10. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидэд зориулсан сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, тэднийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.11. Хүүхдүүдийг асран хамгаалагчид нь буцаах талаар хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

3.12. Төвийн санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийг хөдөлмөрт дур сонирхолтой болгох зорилгоор туслах аж ахуй эрхэлж болно.

3.13. Төвийн хүүхдүүдийг зуны улиралд тав тухтай амрах нөхцлийг хангаж хүүхдийн зуслан ажиллуулна.

3.14. Төв нь Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний дагуу нийслэлийн төсвөөс санхүүжилт авч тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж байна.

3.15. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар баримт бичиг боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

3.16. Төвийг зохих мэдлэг мэргэжил, дадлага туршлагатай, үнэнч, шударга, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлнэ.

3.17. Төвийн багш, ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох болон мэргэжил дээшлүүлэх, амьдрах арга ухаан, хүмүүжил төлөвшлийг бий болгоход чиглэсэн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор урт, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна.

3.18. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн үйлчилгээний албан хаагч, багшийн ёс зүйг чанд сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, омч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн болон хандивын хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж ажиллана.

3.19. Байгууллагын дотоод дэг журмыг чанд сахиулна.

3.20. Хууль тогтоомжид заагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Төвийн эрх**

4.1. Төвийн төсөв, зээл, тусламж, хандивын хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэлд тусган зориулалтын дагуу болон нягтлан бодох бүртгэлийн дагуу зарцуулна.

4.2. Хүүхдийн асран хамгаалах, сурган хүмүүжүүлэх үүргээ нэр төртэй биелүүлж байгаа тэргүүний багш, ажилтнуудад Засгийн газрын 36 дугаар тогтоолоор батлагдсан Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай журмын дагуу нэмэгдэл цалин олгоно.

4.3. Ажиллагсдаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан шаардлагаа биелүүлэхийг шаардах, хууль тогтоомжинд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

4.4. Батлагдсан орон тоонд багтаан хамтлаг, туслах аж ахуй, эрхэлж өөрийн орлогоо нэмэгдүүлж болно.

4.5. Гадаад дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын хууль тогтоомжийн хүрээнд харилцаа холбоо тогтоож хамтран ажиллана.

4.6. Үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлаар шүүх, хяналт, хуулийн бусад байгууллагад гомдол гаргах, хуульд заасан хугацаанд шийдвэрлэхийг шаардана.

4.7. Ашиглагдахгүй болсон илүүдэлтэй байгаа хэрэгцээ шаардлага хангахгүй болсон материал, эд хогшил, тоног тохооромж, техник хэрэгсэл, хүүхдийн хувцсыг худалдах, шилжүүлэх, актлах, устгах асуудлыг нийслэлийн өмчийн газарт санал оруулан шийдвэрлүүлнэ.

4.8. Монгол улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжинд заагдсан бусад эрхийг эдлэнэ.

**Тав. Хориглох зүйл**

5.1. Төвийн захирлын зөвшөөрөлгүйгээр хүүхдийг бусдын асрамжинд шилжүүлэх.

5.2. Хүүхдээр өөртөө үйлчлэх хөдөлмөрөөс бусад ажил эрхлүүлэх, аливаа ажилтныг орлуулах;

5.3. Хүүхдэд арга хэмжээ авах нэрээр хэт хүнд үүрэг даалгавар оногдуулах, хоол, нойрыг нь хасах, хөөх, үг хэлээр доромжлох;

5.4. Хүүхдийг хараа хяналтгүйгээр гадуур сэлгүүцүүлэх, зөнд нь орхих, үл хайхрах, тусгаарлах;

5.5. Хүүхдийг гутаах, доромжлох, хүчирхийлэх, бэлгийн замаар ашиглах, гэдэнд ноцтой гэмтэл учруулах;

5.6. Ял шийтгэлтэй буюу ёс зүйн зөрчилтэй этгээдийг авч ажиллуулах;

5.7. Хүүхдийн зан байдал, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц үйл ажиллагаа, шашны номлол, сурталчилгааг явуулахыг тус тус хориглоно.

### **Зургаа. Бусад зүйл.**

6.1. Төвийн захирал, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээ болон энэ дүрмээр хүлээх үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Төвийн нэрийг барьж, хууль бус үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Долоо. Нэмэлт өөрчлөлт.**

7.1. Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2. Энэхүү дүрмэнд оруулах нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oO-----